



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2014 он



ГАРЧИГ

1.Илтгэгчийн үг: Ерөнхий шүүгч Ц.Зориг	1-2
2.Шүүгч, ажилтнуудын бүтээл	3
3.Улсын Дээд шүүхийн 2014 оны ажлын тайлангийн товч танилцуулга	4-5
4.Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	6-9
5.Иргэний хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	10-14
6.Захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	15-19
7.Бусад асуудлаар...	20-22
8.Тамгын газрын ажлын тайлан	23-26
9.Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан	27-28
10.Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан	29-31
11.Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан	32
12.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан	33-35
13.Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан	36
14.Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан	37-38
15.Дотоод аудитын албаны ажлын тайлан	39
16.Сургалт, семинар	40-43



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Өнгөрч буй онд бид шүүхийн шинэтгэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бодит ажил хэрэг болоход анхаарлаа хандуулсан чухал жил боллоо.

Ялангуяа шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, түүн дотроо шүүгчийн цалин, бусад эдийн засгийн баталгааг нэмэгдүүлэх, процессийн болон материаллаг тулгуур хуулиудыг шүүхийн тухай багц хуульд нийцүүлэх, шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад чиглэн ажилласан онцлогтой байлаа. Тодруулбал,

Эрүү, иргэн, захиргааны процессийн хуулиудийн шүүн таслах ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтыг шүүхийн тухай багц хуульд нийцүүлэх, эрх зүйн орчныг тодорхой болгох ажил хийгдлээ. Цаашид дээрх хуулиудыг болон тэдгээрийн материаллаг зохицуулалтыг шинэчлэн боловсруулах, тэдгээрт санал өгөх суурь шинжтэй ажил ирэх онд хүлээгдэж байна.

Хэдийгээр шүүхийн тухай багц хууль нь харилцаа нэг бүрээрээ төрөлжиж батлагдсан нь сайшаалтай хэдий ч тэдгээрт нийгмийн эрэлт хэрэгцээгээ хангасан эсэх талаар иргэд, хэргийн оролцогчдын болон шүүгч, мэргэжлийн олонхийн тавьсан дүн харилцан адилгүй байна.

Энд ололт, амжилт байгаа хэдий ч алдсан, ухарсан зүйл бас багагүй байгааг сүүлийн үеийн Үндсэн Хуулийн цэцийн шийдвэрлэсэн маргаанууд тодорхой харуулж байна.

Ийм цаг үед бид шүүхийн дээд байгууллагын хувьд шүүн таслах ажиллагааны талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал, иргэд, нийгмийн хэрэгцээ шаардлага, дэлхийн жишиг, монголын туршлагыг харгалзан нэн хариуцлагатай, ажил хэрэгчээр уламжлал, шинэчлэлийг хослуулан ажиллах нь чухал байна. Бид ингэж ажилласаар ч ирсэн, цаашид ч ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Нөгөөтэйгүүр Шүүхийн тухай багц хуульд Улсын Дээд шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар хуулийн албан ёсны тайлбар хийх эрх зүйн орчин бүрдэж, Та бидний шийдвэрийг олон нийт анхааралтай ажиглах боллоо.

Бидний тайлбар эрх зүйн онол, орчин үеийн хандлага, хууль зүйн шинжлэх ухаанд тодорхой байр суурийг эзлэх төдийгүй шүүхийн практик, нийгмийн үзэгдэл



харилцаанд жишиг болох учиртай юм. Тиймээс бид шүүхийн шийдвэр, түүний үндэслэлт байдал, агуулгыг дахин нэг эргэн харж, шүүхийн дээд байгууллагын хувьд бусад шүүхийг манлайлах, үлгэр загвар болох тэргүүн зорилт тавигдаж байгаа бөгөөд энэ чиглэлд манай 3 танхим багагүй ажил хийж, сонгомол, жишиг болохуйц шийдвэр тайлбаруудаа уншигчдынхаа мэлмийд хүргэхээр хэвлэлтэд шилжүүлсэн явдалд баяртай байна.

Мөн 2014 онд Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлж, дагнасан шүүхийн үйл ажиллагаа, төлөвшилт, хийж бүтээсэн ажлын үр дүн, ололт амжилт, алдаа дутагдлыг дүгнэсэн онцлог жил болсныг дурьдах нь зүйтэй.

Энэ хугацаанд шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, харилцан найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаадын зарим орнуудтай хамтран зохион байгуулж буй шүүгчдийн сургалтыг тогтмолжуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэх, тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээр БНХАУ, БНСУ, Тайваний сургалтууд тогтмолжихийн зэрэгцээ олон улсын гишүүнчлэл бүхий шүүх, бусад байгууллага, нэгдэлүүдтэй хамтран ажиллах эхлэлийг тавьлаа.

2014 онд шүүгч, ажилтнуудын маань хөдөлмөрийг үнэлж, Үндэсний их баяр наадам, Тулгар төр байгуулагдсаны 2223 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 808 жил, Ардын хувьсгалын 93 жил, Их эзэн Чингис хааны мэндэлсний 852 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч **Ц.Амарсайхан** “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн **Ж.Тэгшдэлгэр** “Алтангадас одон”-оор, шүүгч **Г.Цагаанцоож** “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар, Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **О.Батсүх**, Шүүгчийн туслах-шинжээч **М.Далайхүү**, **Б.Мөнхзул**, **Т.Жавхлантөгс** нар Улсын Дээд шүүхийн “**Жуух бичиг**”-ээр тус тус шагнагдлаа.

Өнгөрсөн хугацаанд шүүгч **О.Зандраа**, **Б.Батцэрэн**, **Б.Бат-Эрдэнэ**, **Т.Уранцэцэг** нар Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

Шүүгч **Х.Батсүрэн** Монголын шүүгчдийн холбооны тэргүүнээр тус тус томилогджээ.



Шүүн таслах нөр их ажлын зэрэгцээ шүүгч, ажилтнууд маань:

- “Монгол Улсын Дээд шүүх-2013”;
- “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”;
- “Иргэний хуулийн тайлбар”;
- “Процессийн эрх зүйн онол, туршлага”;
- “Процессийн эрх зүйн толь”;
- “Гэрээний эрх зүй-3”;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар-3”;
- “Хувьцаа эзэмшигчийн эрх”;
- “Өрсөлдөөний эрх зүй”;
- “Зээлдүүлэгчийн эрх”;
- “Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн тойм”;
- “Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх 2004-2014” зэрэг нэг сэдэвт бүтээл, гарын авлага, альбомыг дангаар болон хамтран бүтээж, нийтийн хүртээл болголоо.


Мөн өмнө нь дурьдсан хууль зүйн агуулга, тайлбараараа жишиг болохуйц “Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл”, “Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоолын эмхтгэл”-үүд болон “Монгол Улсын Дээд шүүх-2014” танилцуулга, түүнчлэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамж, Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан “Заавар, дүрэм, журмын эмхтгэл” зэргийг хэвлэлтэд тус тус шилжүүлээд байна.






УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улсын Дээд шүүхийн нийт хүлээж авсан 2097 хэргээс




Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 1695 хэргээс







Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн болон захиргааны хэргийн танхимуудын 2014 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2014 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх онтой харьцуулбал:



Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:





ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ




НЭГ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 6 хэрэг дээр хяналтын шатны журмаар эрүүгийн 634, цагаатгалын 8, нийт 648 хэрэг хүлээн авч, 478 эрүүгийн, 6 цагаатгалын буюу нийт 484 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 93 хэргийг хянан буцааж, 55 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо Эрүүгийн хэргийн танхим 16 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан эрүүгийн 648 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 70 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 6.9 хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 593 хэргээс нэг шүүгчид 99 хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 484 хэргийн 57 хувь буюу 276 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 22.3 хувь буюу 108 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 20.6 хувь буюу 100 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.




Өөрчлөлт оруулсан **108** тогтоол, магадлалын **38.8** хувь буюу **42** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **4.6** хувь буюу **5** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **6.4** хувь буюу **7** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **6.4** хувь буюу **7** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **6.4** хувь буюу **7** нь Эрүүгийн хуулийн 55¹¹, 62¹¹ дүгээр зүйлээр, **37** хувь буюу **40** шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **100** тогтоол, магадлалтай хэргээс **55** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **14** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **18** хэргийг (үүнээс 6 нь цагаатгалын хэрэг) **хэрэгсэхгүй** болгож, **13** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгожээ.

Хяналтын журмаар шүүгч Б.Цогт **106**, Д.Эрдэнэбалсүрэн **106**, Б.Батцэрэн **104**, Б.Бат-Эрдэнэ **101**, Т.Уранцэцэг **101**, Д.Ганзориг **75**, нийт **484** хэрэг хуралдаанаар хянан шийдвэрлэсэн, Ерөнхий шүүгчийн ажлын алба **55** эрүүгийн хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн С.Нямжав **419**, шүүгч Б.Цогт **373**, Д.Эрдэнэбалсүрэн **352**, Б.Батцэрэн **344**, Б.Бат-Эрдэнэ **247**, Д.Ганзориг **243**, Т.Уранцэцэг **135**, С.Батдэлгэр **18** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн С.Нямжав **419**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **32**, Б.Батцэрэн **20** Т.Уранцэцэг **13** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч Б.Цогт **93**, Б.Батцэрэн **92**, Д.Эрдэнэбалсүрэн **90**, Б.Бат-Эрдэнэ **80**, Т.Уранцэцэг **70**, Д.Ганзориг **59**, хэргийг **илтгэсэн** байна.



Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2014 оны бүтэн жилийн ажлын ачаалал ажлын



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **21** хүнд холбогдох **6** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **87.3** хувь буюу **423** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **0.6** хувь буюу **3** нь иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн өмгөөлөгчийн гомдлоор, **3.7** хувь буюу **18** нь улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **8.2** хувь буюу **40** нь прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд шүүгч Т.Уранцэцэг **26**, Б.Бат-Эрдэнэ **18**, Д.Ганзориг **14**, Д.Эрдэнэбалсүрэн **14**, Б.Цогт **12**, Б.Батцэрэн **9** нийт **93** хэргийг хянан, дээд шатны прокурор эсэргүүцлээ татан авсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлүүдээр тус тус буцаасан байна.

Тус танхим 2014 онд нийт **134** албан бичиг, **51** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн С.Нямжав **109** албан бичиг, **40** өргөдөл гомдол, шүүгч С.Батдэлгэр **5** албан бичиг, **3** өргөдөл гомдол, Б.Цогт **4** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Т.Уранцэцэг **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Б.Батцэрэн **3** албан бичиг, Д.Эрдэнэбалсүрэн **2** албан бичиг, Д.Ганзориг **2** албан бичиг тус тус хянан шийдвэрлэж, одоо **12** өргөдөл гомдол, албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **232** гарснаас Танхимын тэргүүний “шүүхийн харьяалал тогтоох тухай” захирамж **67**, бусад захирамж **165**, мэдэгдэх хуудас **118** гарсан байна.



ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



1.2. Иргэний хэргийн танхим.

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **30** хэрэг дээр хяналтын шатны журмаар **879**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **103**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **38**, нийт **1050** хэрэг хүлээн авч, **841** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **113** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **37** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **27** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **3** хэргийн харьяаллыг тогтоож, одоо **29** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1050 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **76** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **11,5** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **937** хэргээс нэг шүүгчид **118** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **841** хэргийн **59.8** хувь буюу **503** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **13.9** хувь буюу **117** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, **15.6** хувь буюу **132** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **10.5** хувь буюу **89** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон байна.




Өөрчлөлт оруулсан **132** шийдвэр, магадлалын **74.2** хувь буюу **98** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **25.7** хувь буюу **34** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **117** шийдвэр, магадлалтай хэргээс **87.2** хувь буюу **102** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **12.8** хувь буюу **15** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **117** хэргийн **36.7** хувь буюу **43** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **63.3** хувь буюу **74** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Б.Ундрах **38**, шүүгч Х.Сонинбаяр **138**, Х.Эрдэнэсүвд **136**, А.Доржготов **133**, Ц.Амарсайхан **130**, Г.Цагаанцоож **123**, Д.Цолмон **121**, Д.Тунгалаг **118** хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Б.Ундрах **584**, шүүгч Ц.Амарсайхан **634**, Х.Эрдэнэсүвд **629**, Г.Цагаанцоож **539**, Х.Сонинбаяр **536**, Д.Цолмон **503**, А.Доржготов **487**, Д.Тунгалаг **478** удаа оролцсоноос;



Танхимын тэргүүн Б.Ундрах **550**, шүүгч А.Доржготов **180**, Ц.Амарсайхан **98**, Д.Тунгалаг **25**, Х.Сонинбаяр **18**, Г.Цагаанцоож **4**, Х.Эрдэнэсүвд **3** хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Б.Ундрах **34**, шүүгч А.Доржготов **129**, Х.Сонинбаяр **128**, Ц.Амарсайхан **123**, Х.Эрдэнэсүвд **121**, Г.Цагаанцоож **117**, Д.Тунгалаг **115**, Д.Цолмон **111** хэрийг **илтгэсэн** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2014 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **368** нэхэмжлэгчийн, **498** хариуцагчийн, **12** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **841** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **552**, Хөдөлмөрийн тухай хуулиар **181**, Гэр бүлийн тухай хуулиар **42**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **34**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **10**, бусад хуулиар **22** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **289.678.300** /хоёр зуун наян есөн сая зургаан зуун далан найман мянга гурван зуу/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний



113.928.300 /нэг зуун арван гурван сая есөн зуун хорин найман мянга гурван зуу/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим 2014 онд нийт **82** албан бичиг, **42** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Ундрах **30** албан бичиг, **9** өргөдөл гомдол, шүүгч Д.Цолмон **10** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Д.Тунгалаг **5** албан бичиг, **5** өргөдөл гомдол, Г.Цагаанцоож **5** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Х.Эрдэнэсүвд **3** албан бичиг, **8** өргөдөл гомдол, А.Доржготов **3** албан бичиг, **3** өргөдөл гомдол, Х.Сонинбаяр **3** албан бичиг, Ц.Амарсайхан **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол тус тус хянан шийдвэрлэж, **17** албан бичиг, **3** өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэхээр Тамгын газар болон бусад танхимд шилжүүлж, одоо **9** албан бичиг, өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн танхим 2014 оны байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- Монголын Залуучуудын намыг 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзаж.
- Монголын либерал намын даргын үүрэг гүйцэтгэгчийг 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор бүртгэж;
- Хөдөлмөрийн Үндэсний намын ээлжит бус их хурлаар намын товчилсон нэрийг “ХҮН” гэж өөрчилснийг, намын даргаар Сүхбатын Зоригтбаатар сонгогдсон болохыг 2014 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор бүртгэж;
- Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намыг 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзсан байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **722** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **498**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **194**, “Гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай” **12**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **10**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **4**, “харъяалал тогтоох” **2**, “хэргийн хугацаа сунгах тухай” **1**, “нэхэмжлэгчийг эрх залгамжлагчаар солих тухай” **1** шүүгчийн захирамж тус тус гарчээ.




ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ



1.3. Захиргааны хэргийн танхим.

Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 8 хэрэг дээр хяналтын шатны журмаар 316, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 42, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 27, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой 6 нийт 399 хэрэг хүлээн авч, 306 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 14 хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай 27 хүсэлтийг шийдвэрлэж, 40 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар нийт хүлээн авсан 399 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 46 өдөр хуралдаж, **өдөрт дунджаар 7.2** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн 357 хэргээс нэг шүүгчид 44.6 хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн захиргааны 306 хэргийн 70.9 хувь буюу 217 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 11.1 хувь буюу 34 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 17.9 хувь буюу 55 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Хүчингүй болгосон 55 шийдвэр, магадлалтай хэргийн 36.3 хувь буюу 20 хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, 16.3 хувь буюу 9 хэргийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 1.8 хувь буюу 1 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож нэхэмжлэлийг хангасан, 30.9 хувь буюу 17 хэргийн магадлал хүчингүй, шийдвэр хэвээр, 14.5 хувь буюу 8 хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.




Өөрчлөлт оруулсан **34** шийдвэр, магадлалын **47.0** хувь буюу **16** нь хууль буруу хэрэглэсэн, **50.0** хувь буюу **17** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **2.9** хувь буюу **1** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулсан.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **27** хэргийн **23** хэргийн хүсэлтийг хангаагүй, **4** хэргийн хүсэлтийг хангасан байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн М.Батсуурь **12**, шүүгч Д.Мөнхтуяа **53**, Л.Атарцэцэг **52**, Ц.Сумъяа **51**, Ч.Тунгалаг **51**, П.Цэцгээ **50**, Х.Батсүрэн **47**, О.Зандраа **41** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн М.Батсуурь **288**, шүүгч Ц.Сумъяа **163**, Х.Батсүрэн **160**, Ч.Тунгалаг **158**, Д.Мөнхтуяа **156**, Л.Атарцэцэг **137**, П.Цэцгээ **137**, О.Зандраа **62** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн М.Батсуурь **262**, шүүгч О.Зандраа **52**, Ц.Сумъяа **6**, Х.Батсүрэн **5**, П.Цэцгээ **5**, Д.Мөнхтуяа **2**, Л.Атарцэцэг **1** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн М.Батсуурь **12**, шүүгч Ч.Тунгалаг **51**, Л.Атарцэцэг **48**, Ц.Сумъяа **48**, Д.Мөнхтуяа **46**, П.Цэцгээ **46**, Х.Батсүрэн **45**, О.Зандраа **37** хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2014 оны ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **111** оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **98** нэхэмжлэгчийн, **74** хариуцагчийн, **17** гуравдагч этгээдийн, **6** гомдол гаргагчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Харин хяналтын журмаар шийдвэрлэгдсэн **145** хэргийн нэхэмжлэлийг хангаж, **56** нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдэснийг хэрэгсэхгүй болгож, **100** нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, **5** захиргааны актыг түдгэлзүүлжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **306** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Газрын маргаан **88**, бусад маргаан **67**, төрийн албаны маргаан **70**, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай маргаан **25**, татварын маргаан **17**, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **15**, Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан **10**, Ашигт малтмалын маргаан **8**, сонгуулийн маргаан **6** хэрэг байна.

Мөн хугацаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **14,320,800** /арван дөрвөн сая гурван зуун хорин мянга



найман зуу/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **3,861,000** /гурван сая найман зуун жаран нэгэн мянга/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2014 онд** нийт **32** албан бичиг, **15** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн М.Батсуурь **15** албан бичиг, **9** өргөдөл гомдол, шүүгч Л.Атарцэцэг **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Д.Мөнхтуяа **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Ц.Сумъяа **3** албан бичиг, Ч.Тунгалаг **2** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Х.Батсүрэн **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, О.Зандраа **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, П.Цэцгээ **2** албан бичгийг тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **417** гаргаснаас бүрэлдэхүүн томилох тухай **212**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **104**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **55**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол **27**, “гомдол хэлэлцэхээс татгалзах тухай” **4** “гомдол гаргаагүйд тооцох тухай” **3**, шүүгчийн захирамж, хэргийн хугацаа сунгасан **1**, бусад захирамж, тогтоол **11** байна.



ХОЁР. БУСАД АСУУДЛААР

Энэ хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид

- “Согтуурч, мансуурч донтох эмгэгтэй хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай”;
- “Гэмт хэргийн тухай”;
- “Зөрчлийн тухай”;
- “Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай”;
- “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай” ;
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”;
- “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай”;
- “Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулиуд;
- “Ялтан шилжүүлэх тухай Бүгд найрамдах Казакастан Улс, Монгол Улс хоорондын хэлэлцээр” төсөлд;

Иргэний хэргийн танхимын шүүгчид

- “Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай”, “Арбитрын хуулийн шинэчилсэн найруулга”;
- “Хуулийн этгээдийг бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” хуулиуд;
- “Шүүхэд иргэний хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шүүх хуралдаанд бэлтгэх, иргэний хавтас хөтлөх стандарт, аргачлал”;
- “Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журам”-ын төсөлд;

Захиргааны хэргийн танхимын шүүгчид

- “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай” хууль;
- “Шүүхэд захиргааны хэрэг, нэхэмжлэл, гомдол хүсэлтийг хүлээн авч бүртгэх , шүүх хуралдаанд бэлтгэх стандарт, аргачлал”-ын төсөлд;



Улсын Дээд шүүхийн шүүгч нар

- **“Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”;**
- **“Хэргийн индексийн журам”;**
- **“Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журам”;**
- **“Төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх журам”-ын төсөлд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.**

Харин Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **С.Нямжав**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ**, **Б.Батцэрэн**, **Т.Уранцэцэг**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар **“Гэмт хэргийн тухай”**, **“Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай”** хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Б.Батцэрэн** **“Хууль сахиулах үйл ажиллагааны тухай”**-ийн ажлын хэсгийн гишүүнээр, **“Эрүүгийн хэргийн мониторинг”**, **“Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн төсөл боловсруулах”** ажлын хэсгийн ахлагчаар;

Шүүгч **Б.Цогт** **“Өршөөл үзүүлэх тухай”** хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Б.Ундрах** **“Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга”**, **“Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулга”**, **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”**-ын ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Д.Тунгалаг** **“ЖАЙКА-ийн Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”**-ийн ахлагчаар;

Шүүгч **Д.Цолмон** **“Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга”**-ын ажлын хэсгийн гишүүнээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** **“Захиргааны хэргийн мониторинг”**-ийн ажлын хэсгийн ахлагчаар;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **О.Зандраа**, **Ц.Сумъяа** нар **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”**-ын ажлын хэсгийн гишүүнээр;

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Б.Ундрах**, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Л.Атарцэцэг**, **Б.Батцэрэн**, **О.Зандраа**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар **“Хуульчийн сонгон шалгаруулалт”**-ын ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилласан байна.

Мөн Эрүүгийн хэргийн танхим өнгөрсөн хугацаанд **“Шүүн таслах ажиллагааны алдаа, зөрчлийн талаар”** тойм;

Шүүгч **Т.Уранцэцэг** **“Мөнгө угаах гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн талаар”** тойм;



Иргэний хэргийн танхимын тэргүүн **Б.Ундрах** “ИХШХШТХ-ийг шүүхийн практикт хэрэглэхэд анхаарах зарим асуудлын талаар” зөвлөмж;

Шүүгч **Ц.Амарсайхан, Х.Эрдэнэсүвд** нар “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг, хариуцлага хүлээх үндэслэл” тойм;

Шүүгч **А.Доржготов, Д.Цолмон** нар “Арбитрын үйл ажиллагаан дахь шүүхийн оролцоо” тойм;

Шүүгч **Д.Тунгалаг, Г.Цагаанцоож** нар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлтийн талаарх анхаарах зарим асуудал” тоймыг тус тус боловсруулж, холбогдох шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.



ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР



ГУРАВ. ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР

3.1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр:

Тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн 6-12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаж иржээ.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас **“Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2014 оны байдлаар шинэчлэгдсэн маягтын дахин гаргуулан авч, 25 шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, 1 хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албанд, захиргааны албан хаагчийн 56 хүний материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргажээ.**

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **13 хүний хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг “Авлигатай тэмцэх газар”-т** хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, томилон ажиллуулжээ.

Түүнчлэн **“Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г** шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тамгын газрын дэргэдэх захиргааны зөвлөл **8 удаа** хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **15 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.**

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **160 тушаал гаргасан байна.**

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Хүүхдийн баяр”, “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр”, “Их Эзэн Чингис хааны өдөр”, бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор



сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын **7** удаагийн тушаалаар **13** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар 2013 оноос одоог хүртэл **1918**, энэ онд **470** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын дотоод эрх зүйн дүрэм, журам болон ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, хэвлэлтэд шилжүүлснийг дээр дурьдсан билээ.

Тайлангийн хугацаанд **215** өргөдөл гомдол, **601** албан бичиг, **2035** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3193** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Улсын Дээд шүүх болон Тамгын газар нь Ханнс Зайдел сантай хамтран 2014 оны 6 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жилийн жилийн ойн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Мөн Тахарын албаны тухай хууль болон Хууль зүйн сайд, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны А/96, 90 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу Тахарын албаны нэг ажилтан 2014 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын Дээд шүүхийн шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж, шүүх хуралдааны журам сахиулан ажиллаж байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх хэсэгт “шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх” гэж заасны дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Дээд шүүхийн Тамгын газраас ажлын хэсэг байгуулагдан 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 2005-2011 оны хооронд дахь Хяналтын шатны шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолыг Shuukh.mn сайтад бүрэн эхээр оруулжээ.

Ингэснээр хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг цахим санд байршуулснаар шүүх олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, шүүгч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан



сурагчдад гарын авлага болгох, хуулийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох ач холбогдолтой болсон байна. Мөн шүүхийн нэгдүгээр давхарт интернэт бүхий мэдээллийн киоск, дэлгэцийг байрлуулан иргэд, хэргийн оролцогчдыг мэдээ, мэдээлэл, хууль тогтоомжоор тогтмол хангаж байна.

Өнгөрсөн хугацаанд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоол болон даргын тушаалаар батлагдсан **“Шүүгчид чөлөө олгох журам”**, **“Шүүгч, ажилтанд албан томилолт олгох журам”**, **“Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”**, **“Автомашин хэрэглэх журам”**, **“Монгол Улсын Шүүхийн нууцын журам”**, **“Шүүгч, шүүхийн ажилтанд буцалтгүй тусламж олгох тухай журам”**, **“Ажлын байрны тодорхойлолт батлах тухай”**, **“Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”**, **“Шүүхийн байрны нийтлэг шаардлага батлах тухай”** зэрэг журам, стандарт ирүүлснийг Шүүхийн болон Тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны 192 дугаар тушаалаар батлагдсан **“Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны ажиллах журам”**-д заасны дагуу хамт олны хурлаар Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дэргэд ёс зүйн хороог **5** гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хорооны даргаар Дотоод аудитын албаны ахлах референт **Н.Түмэнбаяр**, нарийн бичгийн даргаар Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **О.Батсүх**, гишүүдээр Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн**, Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт **С.Бурмаа**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанцэцэг** нар сонгогдон ажиллаж байна.

Энэ хугацаанд Улсын Дээд шүүхийн ахмадын зөвлөлийн **18** гишүүнийг Монгол орны үзэсгэлэнт байгальтай танилцуулах зорилгоор Дэлхийн энергийн төв болох “Хамрын хийд”-д аялуулжээ.

Мөн Улсын Дээд шүүхийн **40** гаруй шүүгч, ажилтнуудын эрүүл мэнд, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2014 оны 8 дугаар сарын 14-17-ны өдөр эх орны маань “Швейцарь” гэгддэг Хөвсгөл далайгаар цөөн хоногийн аялал хийсэн байна.

Өнгөрсөн хугацаанд Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Залуучуудын зөвлөлөөс уламжлал болгон зохион байгуулдаг гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээн 2014 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, **Захиргааны хэргийн танхимын баг 2 дахь жилдээ** түрүүлжээ. Харин энэ жилийн тэмцээнд Улсын Дээд шүүхэд шүүгчийн туслахаар ажиллаж байгаад шүүгчээр томилогдсон **С.Батгэрэл**, **Ш.Гандансүрэн**, **Д.Алтанжигүүр**, **Ц.Оч**, **Х.Идэр**,



Б.Батболор, Г.Есөн-Эрдэнэ, М.Пүрэвсүрэн нар “**Шүүгч нарын баг**” бүрдүүлэн оролцсон нь онцлог болсон байна.

Түүнчлэн Хуулийн төв байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын наадам 5 төрөлт тэмцээн 2014 оны 11 дүгээр сарын 14-24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж Улсын Дээд шүүхийн баг тамирчид багийн нийт оноогоор **хоёрдугаар** байрт шалгарсан амжилт үзүүлжээ.

3.2. Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор **Ж.Наранпүрэвийг** Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргаар, **Н.Булгамааг** Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн, **Н.Дагвыг** Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөхийн, **Г.Наранбаатар, Н.Мөнхтулга, Д.Даваадорж, Г.Ууганбаатар, С.Золбоо** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **М. Солонгоог** Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийн, **С.Дархантөгсийг** Дотоод ажил хариуцсан шинжээчийн, **Б.Мөнхсайханыг** Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтний, **Т.Өлзийтүвшин, С.Баяртуяа, Б.Дүүрэнжаргал** нарыг шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд, **Г.Ганбаяр, Д.Лхагвасүрэн** нарыг Тамгын газрын жолоочийн, **М.Намууныг** няравын ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас Гэмт хэрэг хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Ч.Баярсүрэн, Шүүгчийн туслах-шинжээч М.Мөнхтөр, А.Зүмбэрэл** нар чөлөөлөгдсөн байна.

Мөн Тамгын газрын даргын тушаалаар Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт **Д.Отгонбаатарыг** Захиргаа удирдлагын хэлтсийн даргын, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээч **С.Бурмааг** Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референтийн, Ёслол хүндэтгэл, гадаад зочны ажил хариуцсан шинжээч **Д.Тулгыг** Гадаад хамтын ажиллагааны асуудал хариуцсан ахлах референтийн, Шүүгчийн туслах-шинжээч **Ц.Батзаяаг** Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчээр, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **Б.Хүрэлтулга, Б.Өлзийхишиг, Т.Болортуяа** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд дэвшүүлэн ажиллуулжээ.

Улсын Дээд шүүхийн Тамгын газраас 2002-2014 оны хооронд **45** хүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалд



томилогдсоноос анхан шатны шүүхэд **35**, давж заалдах шатны шүүхэд **7**, хяналтын шатны шүүхэд **1** хүн ажиллаж байна.

Энэ хугацаанд дээрх шүүгч нараас Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр **1**, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчээр **7** хүн томилогджээ. Харин 2014 онд хамгийн олон захиргааны ажилтан шүүгчийн албан тушаалд томилогдсон. Тухайлбал,

Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны дарга **Н.Долгорсүрэн** Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгчийн, Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **Э.Амин-Эрдэнэ**, Шүүгчийн туслах-шинжээч **Ж.Сэмжид**, Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Ц.Сансармаа** нар Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн, Шүүгчийн туслах-шинжээч **Б.Ундраа** Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, **Б.Мөнхзул** Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн, **Д.Янжиндулам** сум дундын 5 дугаар шүүхийн шүүгчийн, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч **Х.Идэр** Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилогдсон байна.

Тайлангийн хугацаанд:

Хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн**, Төсвийн асуудал хариуцсан референт-Ахлах нягтлан бодогч **А.Эрдэнэцэцэг**, Цахим засаглал, хэвлэл хэвлэл мэдээлэл хариуцсан шинжээч **Д.Оюунчимэг**, Шүүгчийн туслах-шинжээч **Т.Жавхлантөгс**, шинжээч **Н.Мөнгөнцэцэг**, **С.Бурмаа**, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга **Т.Болортуяа** нарын төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг,

Улсын Дээд шүүхийн Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч **С.Сундуйжав**, Шүүгчийн туслах-шинжээч **Б.Ундраа**, **М.Мөнхтөр**, **М.Далайхүү**, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч **Х.Идэр** нарын зэрэг дэвийг тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын дагуу шинэчилсэн загварын дагуу давхардсан тоогоор **84** хүний үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, **43** хүний хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулжээ.

Тамгын газрын ажилтнуудын үйл ажиллагаа, хэргийн хөдөлгөөний болон баримт бичгийн стандартын хэрэгжилт, зохион байгуулалтын ажилд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх зорилгоор Тамгын газрын даргын 2014 оны 135 дугаар тушаалаар



удирдамж батлагдсаны дагуу Захиргаа удирдлагын хэлтсийн дарга **Д.Отгонбаатар**, Ерөнхий шүүгчийн ажлын албаны зөвлөх **Н.Дагва**, Дотоод аудитын албаны ахлах референт **Н.Түмэнбаяр**, Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт **С.Бурмаа**, Дотоод ажил хариуцсан шинжээч **С.Дархантөгс** нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 2014 оны 11 дүгээр сарын 10-24-ний өдрийг хүртэл удирдамжид тусгагдсан ажлыг гүйцэтгэж, ажилтнуудын гаргасан алдаа зөрчлийн талаар дотоод аудитын эрсдлийн зөвлөмж, илтгэх хуудас гарган Тамгын газрын дарга болон нийт ажилтнуудад танилцуулжээ.

3.3. Шүүхийн практик судлах чиглэлээр:

Тус хэлтэс нь Эрүүгийн, Иргэний болон Захиргааны хэргийн танхимуудаас ирж буй шаардлагатай судалгааг түргэн шуурхай, бодитой гаргахад анхаарч, орон нутгийн шүүхүүдийн судалгааны арга зүй, арга, аргачлалыг сайжруулахад чиглэн ажиллажээ.

2014 онд тус хэлтэс 44 судалгаа хийсний 45 хувийг чанарын судалгаа эзэлжээ. Тухайлбал: Монгол Улсын Ерөнхийлөгчийн захиалгаар Үндсэн хуулийн цэцээс зохион байгуулж буй **"Үндсэн хуулийн хэрэгжилтийн судалгаа"**-ны **"Шүүх эрх мэдэл" Бүлгийн судалгаа**-ны талаар;

Монгол Улсын Их Хурлын захиалгаар **"Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр"**-ийн төсөл, хөтөлбөртэй холбогдуулж гарах 8 төрлийн журам, төслийн хүрээнд **"Албан тушаалтан, ажилтныг ажил эрхлэхээс чөлөөлөх, огцруулах, түдгэлзүүлэх, татгалзах тухай асуудлын эрх зүйн зохицуулалтын судалгаа"**, **"Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоолын хэрэглээнд үнэлгээ-шинжилгээ хийх аргачлал"** боловсруулахтай холбоотой гадаад улс орнуудын хууль тогтоомжийн мониторингийн эрх зүйн журамлалтын талаар;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санаачилгаар **"Монгол Улсын шүүхээс 2008-2013 оны шүүн таслах ажиллагааны тойм газрын зураг"** –ийн талаар;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн захиалгаар **"Шүүгчийн хараат бус ажиллах, амьдралд хүрэлцээтэй байх эдийн засгийн баталгаа"**, **"Ганцаарчилсан болон утсан харилцааны ярилцлагын судалгаа"**, **"Шүүх хуралдааны тов тогтоох тухай журам"**-ын талаар;



Эрүүгийн хэргийн танхимын захиалгаар “**Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардал**”, “**Гадаад улс орнуудын хяналтын шатны шүүхийн бүрэн эрх**”, “**Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт 2009-2013 он**”, “**Мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэлт 2009-2013 он**”, “**Шинэ төрлийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, шүүн таслахад анхаарах асуудал**”, “**Албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдал**”, “**Шүүхээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд буцаасан хэрэг**”, “**Шүүхээс мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэж ирсэн байдал, анхаарах асуудал зэрэг онолын болон практик**”-ын талаар;

Иргэний хэргийн танхимын захиалгаар “**Анхан шат, хяналтын шатны шүүхээр 2013 онд гэм хор учруулснаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэсэн хэрэг**”, “**Онцгой ажиллагааны журмаар ажилласан жил тогтоосон иргэний хэргийн судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар**”, “**Компанийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн хэргийн судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар**”, “**Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар 2003-2013 онуудад шийдвэрлэсэн хэргийн тоо**”, “**Гэр бүлийн холбогдолтой ИХШХШТХуулийн 126 дугаар зүйлийн 126.2 дахь хэсэгт зааснаар шийдвэрлэсэн хэргийн тоог сүүлийн 3 жилийн байдлаар**”, “**Нийт шүүгчдийн хуралдааны тухай**”, “**АНУ, БНСУ, ХБНГУ, Япон Улсын дээд шүүхийн бүтэц, зохион байгуулалтыг харьцуулан судалж, холбогдох хуульд өөрчлөлт оруулах боломжийн тухай дүгнэлт, саналын танилцуулга**”, “**2013 онд Багануур, Налайх, Сүхбаатар дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаан хойшилсон хэрэг**”-ийн талаар;

Захиргааны хэргийн танхимийн захиалгаар “**Орон нутгийн шүүхүүдээс нотариатчтай холбоотой хэрэг маргаан шийдвэрлэлт**”, “**Монгол Улсын захиргааны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа-10 жилд дэлгэрэнгүй**”, “**Монгол Улсын зээлийн харилцаа ба зээлдүүлэгчийн эрх, онол**”, “**Гадаад улс орнуудын захиргааны шүүхийн прецедентийн танилцуулга**”-ын талаар;

МУИС-ийн ХЗС-ийн захиалгаар “**Монгол Улсын хэмжээнд гадаадын иргэдтэй холбоотой 2003-2012 онуудад шийдвэрлэсэн иргэний хэрэг**”-ийн талаар тус тус судалгаа, тойм гаргаж холбогдох газруудад хүргүүлжээ.

Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн** Ерөнхийлөгчийн санаачласан “**Төрийн өндөр албан тушаалтны хариуцлагын тухай хууль**”-ийн төслийг бэлтгэх ажлын хэсэгт орж ажилласан байна.

Тус хэлтэс нь “**Монголын төр эрх зүй**”, “**Улсын Дээд шүүхийн мэдээлэл**” зэрэг улирал тутмын сэтгүүлийн дугааруудыг эрхлэн гаргажээ.



3.3.1. Шүүхийн статистикийн тоон мэдээ, мэдээллийн чиглэлээр:

2014 оны эхний хагас жилийн шүүн таслах ажлын мэдээ, тайлангийн танилцуулгыг гаргаж, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2008 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 60 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг хүргүүлэх заавар”-ын дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлжээ.

3.3.2. Эрх зүйн системчлэл, мэдээлэл зүйн чиглэлээр:

Шүүхийн практик судлалын хэлтэс нь Монгол Улсын хуулиуд, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимуудаас гаргасан зөвлөмж, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэн захиргааны болон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолуудаар Улсын Дээд шүүхийн мэдээллийн “Нэгдсэн сан”-г баяжуулж, зарим эрх зүйн актуудыг албан ёсны сайт (www.Legalinfo.mn)-д байршуулжээ.

Тус хэлтэс нь Монгол Улсын хууль **132** хууль, Улсын Их Хурлын **71** тогтоол хүлээн авч, Улсын Их Хурлын **124** тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг хуулийн эх хувь болон Төрийн мэдээлэл сэтгүүлийн хувьд тухай бүрт баяжилт хийхийн зэрэгцээ хуулийн цахим санд өөрчлөлтийг оруулсан байна.

Мөн 2012, 2013, 2014 оны Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт мөн Төрийн мэдээлэл сэтгүүлийг дугаар бүрээр товъёог үйлдэж хавтаслаж архивлах ажлыг зохион байгуулжээ.

3.3.3. Эрдэм шинжилгээ, сургалтын болон бусад ажлын талаар:

Хэлтсийн дарга Ч.Нямсүрэн Ерөнхийлөгчөөс санаачилсан **"Төрийн өндөр албан тушаалтны хариуцлагын тухай хуулийн төсөл"**, **"Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенц"**-ийн хэрэгжилтийн 2 дугаар илтгэлийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан байна.

Мөн Ч.Нямсүрэн **"Торгох ялыг өөр төрлийн ялаар солих онол практикийн асуудал"**, **"Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк санхүүгийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны зарим асуудал"**, **"Шүүхийн шинжилгээний байгууллага ба мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн**



зохицуулалтын тулгамдсан асуудал" зэрэг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцож илтгэл хэлэлцүүлжээ.

Тус хэлтэс нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм”** (2004-2014) нэгдсэн судалгааг хийж хянуулан, Захиргааны хэргийн шүүхийн 10 жилийн ойд зориулан гарын авлага болгон хэвлүүлсэн.

Мөн **“Торгох ялыг өөр төрлийн ялаар солих онол практикийн асуудал”, “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд банк санхүүгийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны зарим асуудал”, “Шүүхийн шинжилгээний байгууллага ба мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал”** зэрэг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлжээ.

Хэлтсийн дарга Ч.Нямсүрэн нь дээрх сэдвийн хүрээнд телевизийн нэвтрүүлэг 1 удаа, сонины ярилцлага 1 удаа өгсөн байна.

3.4. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн 2014 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах, төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хангах, үнэн зөв тайлагнах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд шинэчлэл, бодлогын шинжтэй ажлуудыг дэмжин санхүүжүүлээ.

Үндэсний Аудитын газраас Улсын Дээд шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, “Улсын Дээд шүүхийн 2013 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан УСНББҮУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэн, “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн болно.

Улсын Дээд шүүхийн 2014 оны төсвийн төсөлд урсгал төсвийг 8.2 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг 14.2 тэрбум төгрөг буюу нийт 22.4 тэрбум төгрөгөөр төсөвлөж хүргүүлснээс “Монгол Улсын 2014 оны төсвийн тухай” хууль түүнд оруулсан өөрчлөлтөөр Улсын Дээд шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал төсвийг 3,4 тэрбум төгрөгөөр тодотгон баталж, төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөж хүргүүлсэн төсөл, арга хэмжээ тусгагдаагүй батлагдсан.



Батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулж, 3.2 тэрбум төгрөг буюу 94%-ийн төсвийн гүйцэтгэлтэй гарснаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2.4 тэрбум төгрөг, бараа үйлчилгээ, тэтгэмжийн зардалд 0.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Тухайлбал: Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн нийт 51 хүнд **112.8** /нэг зуун арван хоёр сая найман мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас батлагдсан төсвийн дагуу **192.0** /нэг зуун ерэн хоёр сая/ төгрөгийг олгосон байна.

3.5. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Тус хэлтэс нь Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, Шүүхийн тухай багц хуулийн хүрээнд шүүхэд хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлийн талаар давхардсан тоогоор өдөр тутмын сонинд **135**, телевизэд **195**, радиод **61**, вэб сайтуудад **403** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ.

Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **105** мэдээг олон нийтэд хүргэсэн байна.

3.5.1. Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

“Шүүхийн тухай багц хуулиудыг сурталчлах, тэдгээрийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах”, “Захиргааны хэргийн шүүхийн 10 жилийн үйл ажиллагааны үр нөлөө, цаашдын хандлага” сэдвээр **Монголын Үндэсний олон нийтийн телевиз, MN-25, Eagle, Монгол /HD/ телевизүүдээр** нэвтрүүлэг бэлтгэхэд хамтарч ажилласан байна. Тухайлбал,

Улсын Дээд шүүхийн шүүгч **О.Зандраа** 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Монгол /HD/ телевизийн “**Энэ л асуудал**” нэвтрүүлэгт оролцож “**Захиргааны хэргийн шүүхээр нийтийн эрх ашгийг хамгаалсан хэргүүд**” сэдвээр;

Шүүгч **Л.Атарцэцэг** 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Монгол /HD/ телевизийн “**Энэ л асуудал**” нэвтрүүлэгт оролцож “**Төрийн албаны маргаан**” сэдвээр;

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдөр С1 телевизийн “**VIP тодруулга**” нэвтрүүлэгт оролцож “Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа” сэдвээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 5 дугаар сарын 22-ны өдөр МҮОНТ-ийн “**Цаг үе, үзэл бодол**” нэвтрүүлэгт оролцож “**Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жил**” сэдвээр;



Улсын Дээд шүүхийн захиалгат нэвтрүүлгээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Ц.Цогт** 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдөр MN25 телевизийн “Хэн юу хэлэв” нэвтрүүлэгт оролцож **“Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа, ач холбогдол”** сэдвээр;

Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн** 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Монгол /HD/ телевизийн “Тодруулга” нэвтрүүлэгт оролцож “Гэр бүлийн маргааны асуудал” сэдвээр;

Шүүгч **Х.Батсүрэн** 2014 оны 6 дугаар 03-ны өдөр Eaglenews телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт оролцож **“Захиргааны хэргийн шүүхийн ач холбогдол, хийсэн ажил”** сэдвээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Eaglenews телевизийн “Бадарчийн Жаргалмаа”- нэвтрүүлэгт оролцож **“Захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, иргэдийн эрх ашгийг хамгаалсан талаар”** сэдвээр;

Шүүгч **Л.Атарцэцэг** 2014 оны 6 дугаар сарын 03-ны өдөр “Айст” телевизийн ярилцлагын цагт оролцож **“Захиргааны хэргийн дагнасан шүүхийн ач холбогдол, үр нөлөө”** сэдвээр тус тус ярилцлага өгчээ.

Тус хэлтэс Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран **“Эрх зүйн хөтөч”** телесэтгүүлийг 5 дахь жилдээ амжилттай бэлтгэн явууллаа. 2014 оны байдлаар 6 нэвтрүүлгийг хамтран бэлтгэж явуулжээ. Тухайлбал,

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **О.Зандраа**, **П.Цэцгээ** нар 2014 оны 6 дугаар сарын 04-ний өдөр **“Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны талаар”** ярилцлага өгсөн байна.

Мөн Улсын Дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимаас 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр **“Гэр бүлийн маргаан”**, 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр **“Залилан мэхлэх гэмт хэргийн сэдвээр”**, 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр **“Шүүхэд төлөөлөх эрхийн асуудал”**, 2014 оны 12 дугаар сард **“Нийгмийн даатгалын асуудлаар”** **“Гэр бүлийн дундын өмчийн асуудал”** сэдвээр зохиомжит нэвтрүүлэг хийжээ.

3.5.2. Радиоогийн нэвтрүүлгийн хувьд:

Монголын Үндэсний олон нийтийн радиоогийн хууль эрх зүйн **“Тод журам”** нэвтрүүлэгтэй хамтран ажиллаж, Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан болон Шүүхийн багц хуулиуд болон шүүхээр шийдвэрлэсэн тодорхой хэргийн шийдвэр дээр үндэслэсэн жүжигчилсэн



зохиомж, тодорхой хэрэг маргааны талаар шүүгчийн ярилцлага бүхий нийт 19 нэвтрүүлгийг сонсогчдын хүртээл болгоод байна. Үүнд:

Улсын Дээд шүүхийн захиалгат нэвтрүүлгээр Сум дундын 7 дугаар шүүхийн шүүгч **Д.Оюундарь** 2014 оны 1 дүгээр сард “**Эвлэрүүлэн зуучлалын асуудал**” сэдвээр;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүгч **Ц.Цогт** 2014 оны 1 дүгээр сард “**Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль**” сэдвээр;

Шүүгч **О.Зандраа** 2014 оны 02 дугаар сард “**Монгол Улсын Шүүхийн тухай хууль**” сэдвээр;

Төв аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч **Э.Ариунаа** 2014 оны 2 дугаар сард “**Өмчлөх эрхийн асуудал**” сэдвээр;

Шүүгч **Б.Батцэрэн** 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдөр “**Гэмт хэргийн тухай хуулийн төсөл**” сэдвээр;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Д.Батбаатар** 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдөр “**Монгол Улсын Шүүхийн тухай хууль**”, “**Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль**” сэдвээр;

Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч **З.Гулбарша** 2014 оны 3 дугаар сарын 31-ний өдөр “**Шүүхийн үйл ажиллагаа, төрийн албаны маргаан**” сэдвээр;

Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүхийн шүүгч **Б.Болормаа** 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр “**Шүүхийн үйл ажиллагаа, татварын маргаан**” сэдвээр;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Д.Баатархүү** 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “**Газрын маргаан**” сэдвээр;

Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Батсүрэн** 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдөр “**Шүүхийн үйл ажиллагаа**” сэдвээр;

Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн шүүгч **У.Бадамсүрэн**, 18 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч **Б.Энхтайван** нар 2014 оны 6 дугаар сарын 02-ны өдөр “**Захиргааны хэргийн шүүх 10 жилд**” сэдвээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 9 дүгээр сард “**Шүүхийн хараат бус байдал**” сэдвээр;

Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** 2014 дүгээр сарын 11 дүгээр сарын 27-ны өдөр “**Шүүхийн төсвийн асуудлаар**” сэдвээр;



Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** 2012 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “**Шударга ёсны тухай асуудлаар**” сэдвээр тус тус ярилцлага өгчээ.

Түүнчлэн “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдвээр болон Шүүхийн тухай багц хуулиуд болон шүүхийн шинэчлэлийн талаар Улсын Дээд шүүхийн болон бусад шүүхийн шүүгч, захиргааны ажилтнуудын ярилцлагыг “**Соёмбо**”, “**Тусгал**”, **FM-101.7 радио** нэвтрүүлгүүдээр тус тус олон нийтэд хүргэсэн байна.

3.5.3. Сонин, сайтын нийтлэлийн хувьд:

Шүүхийн үйл ажиллагаа, Шүүхийн тухай багц хууль, шүүхээр шийдвэрлэсэн зарим төрлийн гэмт хэрэг, цаг үеийн асуудалтай холбоотойгоор Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнүүд, шүүгчид, шүүхийн ажилтнууд, иргэдийн давхардсан тоогоор нийт **29** ярилцлага;

Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр болон шүүхийн шинэчлэлтэй холбоотой давхардсан тоогоор **22** нийтлэл, өгүүллэг өдөр тутмын болон бусад сонин, вэб сайтад нийтлүүлсэн байна.

Хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж буй сэтгүүлчдэд зориулан уламжлал болгон явуулдаг “**Шүүхийг сурвалжлах нь**” сэдэвт цуврал сургалтын уралдааныг 2014 оны 02 дугаар сард дүгнэсэн байна.

3.6. Ерөнхий шүүгчийн ажлын алба.

Тус алба нь тайлангийн хугацаанд нийт **112** албан бичиг, өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгчээ.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **55**, иргэний **113**, захиргааны **42**, нийт **210** хэрэг хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, хариу өгсөн байна.

Ажлын албаны дарга, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **76** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан



алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор **16** шүүгч, **31** ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Улсын Дээд шүүх 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгуулах талаар нийт **7** хэргийн материал хүлээн авснаас **6** хэргийг хянан хэлэлцэж, **6** тогтоолоор **16** хүнийг цагаатгасан байна. Мөн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **63** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ **49** үнэмлэх олгожээ.

3.7. Шүүхийн Гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна.

Танхимын тэргүүн **Б.Ундрах**, шүүгч **Д.Тунгалаг** нар нь 2014 оны 1 дүгээр сарын 14-24-ний өдрүүдэд Япон Улсад зохион байгуулагдсан “**Эвлэрүүлэн зуучлалын сургагч багш нарыг сургах-хөтөлбөрт**” сэдэвт;

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ**, **Б.Батцэрэн**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар нь 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс 2 дугаар сарын 10-ны өдрүүдэд Канад Улсад зохион байгуулагдсан “**Шүүн таслах ажиллагааны онцлог, цагдаа, прокурор, шүүхийн хамтын ажиллагаа**” сэдэвт;

Шүүгч **Т.Уранцэцэг** нь 2014 оны 6 дугаар сарын 04-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Ардын Дээд Шүүхийн дэргэдэх “**Шүүгчдийн Үндэсний коллеж**”-д “**Шүүгчдийг давтан сургах**” сэдэвт;

Улсын Дээд шүүхийн **П.Цэцгээ**, **Х.Сонинбаяр**, **Г.Цагаанцоож** нар БНСУ-ын Дээд шүүхээс 2014 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “**Дээд шүүхийн шүүгчдийн сургалт-хөтөлбөрт**” сэдэвт;

Улсын Дээд шүүхийн Танхимын тэргүүн, шүүгчид Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан Олон Улсын онол практикийн “**Захиргааны хэргийн шүүх-10 жил**” сэдэвт;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг** тэргүүтэй Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар Ази Номхон далайн бүс нутгийн хуульчдийн холбоо /LAWASIA/-оос Тайланд Улсын Бангкок хотноо 2014 оны 10 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд



зохион байгуулсан “**27 дугаар Ази номхон далайн бүс нутгийн шүүгч нарт тулгамдсан асуудал**” сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч **Х.Батсүрэн** 2014 оны 10 дугаар сарын 19-31-ний хоорнд Далайн орнуудтай харилцах Монголын нийгэмлэгээс Тайванийн Тайпе хотноо зохион байгуулсан “**Монголын шүүгч нарт зориулсан сургалт**” сэдэвт;

Улсын Дээд шүүхийн шүүгч **Ц.Амарсайхан** 2014 оны 12 дугаар сарын 9-18-ний өдрүүдэд БНЭУ-ын Лакнау хотноо зохион байгуулагдсан “**Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 15 дүгээр бага хурал**” сэдэвт чуулга уулзалт, олон улсын бага хурал, сургалтад тус тус оролцжээ.

3.7.1. Гадаад айлчлалын хүрээнд:

Танхимын тэргүүн **С.Нямжав** нь 2014 оны 3 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд Тайвань Улсад “**Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа**” Азийн сангийн хэрэгжүүлж буй төслийн хүрээнд;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг** тэргүүтэй шүүгч **Б.Цогт**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч **Ч.Хосбаяр** нар Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхийлөгч Сан Хюун Соны урилгаар Нидерландын Вант Улсын Гаага хотноо 2014 оны 11 дүгээр сарын 12-17 өдрүүдэд **Олон Улсын Эрүүгийн шүүхэд** албан ёсны айлчлал тус тус хийжээ.

3.7.2. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:

Захиргааны хэргийн танхимын Тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 6 дугаар сарын 03-ны өдөр ХБНГУ-ын Бавари муж улсын Захиргааны сургуулийн Захирал асан, МУИС-ийн хүндэт доктор **Ю.Харбихыг** хүлээн авч уулзаж, Монгол Улсад Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсанаас хойш 10 жилийн хугацаанд олсон ололт амжилт, анхаарах асуудлууд, цаашдын зорилтын талаар;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг** 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдөр ХБНГУ-ын Ханс Зайдел сангийн Олон Улсын хамтын ажиллагааны Захирал **Сюзан Лютерийг** хүлээн авч уулзаж, хоёр байгууллагын өнөөгийн болоод цаашдын хамтын ажиллагааны талаар;

Захиргааны хэргийн танхимын Тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 6 дугаар сарын 24-ний өдөр БНИУ-ын Шүүхийн Дээд зөвлөлийн дарга **Мичелли Виеттийг** хүлээн авч уулзаж, хоёр улсын шүүхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан туршлагаасаа хуваалцах боломжийн талаар;



Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, 2014 оны 12 дугаар сарын 02 өдөр IDLO-ийн Монгол хариуцсан төлөөлөгч ноён **Carlos R.Escudero** болон хатагтай **Margarita Milikh** нарыг хүлээн авч уулзаж, Худалдааны эрх зүйн мэргэшүүлэх сургалтын төсөл болон Улсын Дээд шүүхийн номын санд Худалдааны эрх зүйн орчин үеийн онол, практикийн нийт 50 гаруй номыг хүлээлгэн өгөх талаар тус тус санал бодлоо солилцож, хамтран ажиллажээ.

3.8. Дотоод аудитын алба:

Улсын Дээд шүүхийн Дотоод аудитын алба нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд болон дотоод аудитын Олон Улсын Мэргэжлийн Практик /The International Professional Practices Framework/-ийн дагуу байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж, системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын эрсдлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад туслан ажиллажээ.

Энэ хугацаанд Дотоод аудитын алба нь оршин байгаа алдаа зөрчлүүдийг тайлагнахаас илүүтэй байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн ажилласан байна. Тухайлбал,

- Төсөв санхүүгийн болон Шүүхийн захиргааны холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, үйл ажиллагааны үр дүнтэй, хэмнэлттэй, үр ашигтай байдлыг хангах;
- Удирдлагын бэлтгэсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн тайлангуудын үнэн зөв ба найдвартай байдлын талаар бодитой баталгаагаар хангах;
- Байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа болон ашиглаж байгаа системийг сайжруулахад туслах;
- Төрийн өмчийн зүй бус ашиглалт, шамшигдал зэргийг зогсоох замаар нийтийн өмчийг хамгаалах;
- Ажилтнуудын ажил үүргийн биелэлтийг сайжруулах, удирдлагаас тавьсан хяналтуудыг дагаж мөрдөхөд нөлөөлөх зэрэг чиглэлээр дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

Мөн байгууллагын үйл ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай ба үр дүнтэй байдалд нөлөөлж болох уламжлалт эрсдлүүд агуулж байгаа үйл ажиллагаануудад анхаарлаа хандуулан Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2014 оны 15 дугаар захирамжаар “Дотоод аудитын төлөвлөгөө”-г батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн



ажилласан байна.

Өнгөрсөн хугацаанд Үндэсний аудитын газраас Улсын Дээд шүүхийн Тамгын газарт аудит хийсэн бөгөөд шалгалтын дүнгээр “хангалттай” гэсэн үнэлгээ авчээ.

Гүйцэтгэлийн аудитыг хийхдээ байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай ба үр дүнтэй байдалд гол анхаарлаа хандуулж ажилласны зэрэгцээ нийцлийн аудитаар хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, бодлого, гэрээний нөхцөл зэргийг дагаж мөрдсөн эсэхийг хамруулжээ.

3.9. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

2014 оны байдлаар Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

Эрүүгийн хэргийн танхим

Шүүгч **Б.Цогт, Д.Ганзориг, Т.Уранцэцэг** нар 2014 оны 01 дүгээр сарын 14-20-ны өдрүүдэд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүгч, ажилтнуудад “**Шүүхийн тухай багц хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд**” сэдвээр;

Шүүгч **Б.Цогт** нь 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулсан “**Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар**” сэдвээр;

Шүүгч **Б.Цогт** нь 2014 оны 5 дугаар сарын 14-16-ны өдөр Австрали Улсын Засгийн газраас санхүүжүүлсэн “**Монгол Улс дахь Засаглалын асуудал, авлига болон орлогын төлөөх гэмт хэрэгтэй тэмцэх санхүүгийн тогтолцоонд хамааруулах тухай**” сэдвээр тус тус хичээл заажээ.

Шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн**, шүүгчийн туслах **Э.Амин-Эрдэнэ, Д.Алтанцэцэг, Ц.Амаргэрэл, Ц.Батзаяа, Н.Нямдаваа, Г.Ууганбаатар, Б.Ундраа** нар нь 2014 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр АНУ-ын Азийн сангаас хэрэгжүүлж буй Засаглал, ил тод байдлыг дэмжих төслийн хүрээнд “**Авлига, албан тушаалын гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа болон байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах нь**” сэдэвт сургалтанд хамрагджээ.

Иргэний хэргийн танхим

Шүүгч **Д.Тунгалаг, Х.Сонинбаяр, Г.Цагаанцоож, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд** нар 2014 оны 3 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Олон улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран Европын сэргээн



босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй **“Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах”** сэдэвт;

Танхимын тэргүүн **Б.Ундрах**, шүүгч **А.Доржготов**, **Д.Тунгалаг**, **Х.Сонинбаяр**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2014 оны 10 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд **“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”** болон Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын **“Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”** –тэй хамтран **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй ба эвлэрүүлэн зуучлал”** сэдэвт сургалтанд тус тус хамрагджээ.

Шүүгч **Ц.Амарсайхан** нь 2014 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын шинжээч нарт зориулан **“Үндсэн хуулийн цэцэд эрх зүйн баримт бичиг боловсруулах аргачлал”** сэдвээр;

Шүүгч **А.Доржготов** нь 2014 оны 05 дугаар сарын 05 дугаар сарын 22-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд **“Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах”** төслийн хүрээнд анхан болон давж заалдах шатны 200 гаруй шүүгчдэд **“Хувьцаа эзэмшигчийн эрх”** сэдвээр;

Танхимы тэргүүн **Б.Ундрах**, шүүгч **Д.Тунгалаг** нар 2014 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн болон орон нутгийн анхан болон давж заалдах шүүхийн шүүгч нарт **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд орсон, нэмэлт өөрчлөлт цаашид, анхаарах зарим асуудал”** сэдвээр;

Шүүгч **Ц.Амарсайхан** нь 2014 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан Шүүхийн мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх сургалтын хүрээнд сэтгүүлчдэд **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдвээр тус тус хичээл заажээ.

Захиргааны хэргийн танхим

Шүүгч **Д.Мөнхтуяа**, **П.Цэцгээ** нар 2014 оны 3 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд **“Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төслийн”** **“Сургагч багш бэлтгэх сургалт-4”** сэдэвт сургалтанд тус тус хамрагдсан.

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 5 дүгээр сарын 09-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн Тамгын газраас зохион байгуулсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын шинжээч нарт зориулан **“Эрх зүйн баримт бичиг боловсруулах аргачлал”** сэдвээр;



Танхимын тэргүүн **М.Батсуурь** нь 2014 оны 05 дугаар 23-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад “**Захиргааны эрх зүйн ойлголт, үндсэн зарчим**” сэдвээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **П.Цэцгээ** нар 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны 208 шүүгчид 40 цагийн “**Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах**” сэдвээр;

Шүүгч **Х.Батсүрэн** 2014 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн Тамгын газраас зохион байгуулсан Үндсэн хуулийн тамгын газрын ажилтнуудад “**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог**”, “**Олон Улсын гэрээг шүүхийн шийдвэрт хэрэглэх нь**” сэдвээр;

Шүүгч **Х.Батсүрэн** 2014 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Захиргааны хэргийн шүүгч нарт “**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**” сэдвээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь** нь 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Ханнс-Зайдалийн сангаас зохион байгуулсан шинээр томилогдсон шүүгч нарт зориулсан “**Захиргааны хэргийн шүүхийн хууль хэрэглэх, тайлбарлах асуудал**” сэдвээр;

Шүүгч **Х.Батсүрэн** нь 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан шинэ шүүгч нарт “**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нотлох баримтыг үнэлэх**” сэдвээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2014 оны 11 дугаар сарын 21-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан шүүхийн мэргэшсэн сэтгүүлч нарт “**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**” сэдвээр тус тус хичээл заажээ.

Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **П.Цэцгээ** нар 2014 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр Иргэний танхимд “**Захиргааны ерөнхий хуулийн хэлэлцүүлэг**” сэдвээр;

Шүүгч **О.Зандраа** 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Хууль зүйн хүрээлэнгээс зохион байгуулсан Б.Чимэд багшийн 80 насны ойд зориулсан Олон Улсын эрдэм шинжилгээний бага хуралд “**Захиргаа шүүхийн үүсэл, өнөө үе**” сэдвээр илтгэл;

Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Д.Мөнхтуяа** нар 2014 оны 12 дугаар сарын 18-нд “**Шилэн дансны тухай хуулийн**” хэлэлцүүлэгт оролцжээ.

Шүүхийн тамгын газар

Улсын Дээд шүүхийн **15** шүүгч, ажилтнуудыг 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл “**Masterbrain**” англи хэлний сургалтын төвийн ахисан **3-р** шатны **32** цагийн;



Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран 2014 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрийг хүртэл хуульчийн гэрчилгээтэй Тамгын газрын 23 захиргааны ажилтанд “Компаний засаглалын эрх зүйн орчин”, “Захиргааны эрх зүйн зарим нэр томъёоны хууль зүйн утга агуулга”, “Төрийн удирдлага ба гүйцэтгэх эрх мэдэл хэмээх ойлголтын адил ба ялгаатай тал”, “Захиргааны эрх зүйн харилцаа арга, зарчим, эх сурвалж, чиг үүрэгт нэвтэрч буй шинэ хандлага”, “Үүргийн гүйцэтгэлийг хангах аргууд, барьцааны нийтлэг зохицуулалт ипотек”, “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг”, “Татварын эрх зүйн өнөөгийн чиг хандлага”, “Хуульчийн мэргэжлийн хариуцлагын дүрмийн агуулга, онцлог”, “Үнэлгээний эрх зүйн зохицуулалт”, “Бусдын эзэмшил, ашиглалтанд эд хөрөнгө шилжүүлэх гэрээ” сэдвээр 4 багц кредит цагийн;

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч **Б.Батцэрэн** Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар 2014 оны 11 дүгээр сарын 05, 11-ний өдрүүдэд “Хуульчийн сонгон шалгаруулалт”-ын шалгалтад орох Тамгын газрын 11 захиргааны ажилтанд “Эрүүгийн эрх зүйн бодлого бодох аргачлал”, “Захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлал” сэдвээр 4 цагийн сургалтыг тус тус зохион байгуулжээ.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

2015 онд бид шүүхийн шинэчлэлийг шинэ шатанд гарган зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх замаар хуулийг албан ёсоор тайлбарлах онол, арга зүйн болон практик шийдлийг томъёолох, нийгмийн бодитой эрэлтэд тулгуурлан Шүүхийн тухай багц хуульд нийцүүлэн тус тусын процессийн болон материаллаг хуулийг боловсронгуй болгох, боловсруулахад оролцох зэргээр түүхэн үүргийг хүлээж байна.

Тиймээс бид өмнөө тавьсан зорилтоо амжилттайгаар гүйцэлдүүлэхэд Та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр